



## **БАДАМЫН ЦЭРЭНДАМБА**

*/Улаанбаатар хотын аймгийн дарга/  
/1931-1932 он/*

Хан Хэнтий уулын аймаг, дайчин Жонон вангийн хошуу, одоогийн Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт 1908 онд төрсөн. Бага насандаа гэрээр бичиг заалгаж, монгол бичиг сайн мэдэх болж. 1928 онд ЗСБНХУ-ын Москва хотод түр хугацаагаар буюу зургаан сар суралцжээ.

Улаанбаатар хотод намын сургуулийн гурав дахь удаагийн элсэлтээр орж төгссөн байна.

Б.Цэдэндамба нь 1929 оны дол дугаар сараас Дотоодыг хамгаалах газарт тагнуулын тасагт төлөөлөгч, мөн хэлтсийн туслах, дарга зэрэг ажил хийж байгаад Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хорооны даргаар сонгогдон ажиллаж байжээ.

1930 оны есдүгээр сард Төв аймаг, Улаанбаатар хотыг нэгтгэн Улаанбаатар аймгийг байгуулсан боловч нийслэл хотын бие даасан байдлыг алдагдуулсан буруу шийдвэр байсан учир удахгүй залруулагдсан байна.

Б.Цэдэндамба 1931 оны 9 дүгээр сарын хоёр ноос Улаанбаатар аймгийн дарга, мөн Улаанбаатар хотын захиргааны даргаар 1932 оны долоодугаар

сарын таван хүртэл 10 сар ажиллаж байхдаа хотын наймдугаар их хурлыг нээж, мөн их хурлаас хотын захиргааны даргаар сонгогдсон.

1932 оны дол дугаар сараас Завхан аймгийн даргаар томилогдон ажиллаж, тэндээсээ удалгүй өвчний учир чөлөөлөгдөж хотод ирээд Хоршооны ерөнхий хорооны гишүүнээр ажиллаж байгаад 1933 оны наймдугаар сард "Лхүмбийн хэрэг" гэгчид холбогдон баривчлагдаж шийтгүүлсэн байна.

Б.Цэдэндамбыг хожим БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх цагаатгалын комиссын 1962 оны 79 дүгээр тогтоолоор цагаатгажээ.